



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: munkhtuyats@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Залруулсан алдаа	21
4.4 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ОХУ	Оросын Холбооны Улс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.БАТЧУЛУУН
ТАНАА

2022.02.25 № 07/401
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar - 41.Docx

001050444

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,591,725,195.93	1,721,563,366.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		90.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		90.00
33	АВЛАГА	507,777,279.89	1,011,894,433.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	78,007.00	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	507,698,822.89	27,137,089.89
33500	Бусад авлага	450.00	984,757,344.00
33510	Байгууллагаас авах авлага	450.00	984,757,344.00
34	УРЬДЧИЛГАА		20,750,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		20,750,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,083,947,916.04	688,918,842.12
35400	Хангамжийн материал	1,083,947,916.04	688,918,842.12
35410	Бичиг хэргийн материал	22,589,390.00	30,495,113.95
35420	Аж ахуйн материал	36,540,673.00	34,301,709.25
35430	Сэлбэг хэрэгсэл	758,000.00	926,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,093,561.64	10,021,293.19
35470	Бусад хангамжийн материал	1,019,966,291.40	613,174,725.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	563,737,682.98	804,014,745.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	563,737,682.98	804,014,745.59
39200	Биет хөрөнгө	336,996,182.98	330,638,245.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	277,097,665.00	359,897,665.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(159,412,458.12)	(211,154,891.16)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	262,938,307.60	279,339,207.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,012,805.03)	(151,997,700.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,309,789.57	133,288,189.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,924,316.04)	(78,734,225.15)
39300	Биет бус хөрөнгө	226,741,500.00	473,376,500.00
39301	Програм хангамж	54,438,000.00	134,023,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,296,500.00)	(5,296,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,600,000.00	344,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,155,462,878.91	2,525,578,111.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,650,720,199.73	2,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,650,720,199.73	2,000.00
41300	Өглөг	1,650,720,199.73	2,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,399,399.73	2,000.00
41360	Бусад өглөг	1,645,320,800.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	1,645,320,800.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	504,742,679.18	2,525,576,111.60
51	Засгийн газрын хувь оролцоо	504,742,679.18	2,525,576,111.60
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	870,951,254.96	870,951,254.96
51200	Хуримтлагдсан үр дүн	(366,391,440.17)	1,654,441,992.25
51210	Өмнөх үеийн үр дүн	5,983,682,674.49	(286,806,440.17)
51220	Тайлант үеийн үр дүн	(6,350,074,114.66)	1,941,248,432.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	182,864.39	182,864.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,155,462,878.91	2,525,578,111.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	28,888,774,874.02	27,799,083,017.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,012,426,244.02	910,619,867.81
120	Нийтлэг татварын бус орлого	1,012,426,244.02	910,619,867.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,878,050.00	35,381,786.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,093,050.00	35,381,786.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,785,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	89,094,011.02	73,140,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	894,454,183.00	802,098,081.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,876,348,630.00	26,888,463,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,848,261,630.00	23,679,617,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,848,261,630.00	23,679,617,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,028,087,000.00	3,208,845,250.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,028,087,000.00	308,845,250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,900,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	32,523,253,379.68	25,857,834,585.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,523,253,379.68	25,857,834,585.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,048,968,744.47	25,750,118,068.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	577,608,733.49	619,917,853.16
210101	Үндсэн цалин	389,157,695.04	430,441,464.39
210102	Нэмэгдэл	145,003,238.45	145,519,012.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,447,800.00	43,957,376.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,036,872.26	81,699,313.02
210201	Тэтгэврийн даатгал	60,718,372.26	56,468,695.07
210202	Тэтгэмжийн даатгал	4,987,900.00	6,705,399.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,155,400.00	4,940,058.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015,900.00	1,235,014.64
210205	Эрүүл мэндийн даатгал	10,159,300.00	12,350,145.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,038,667.00	14,598,970.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,088,200.00
210302	Түлш, халаалт	-	1,696,470.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,667,300.00
210304	Байрны түрээс	9,038,667.00	7,147,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	313,868,817.87	70,239,430.73
210401	Бичиг хэрэг	40,281,555.00	19,744,680.00
210402	Тээвэр, шатахуун	13,467,987.00	12,683,107.23
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,335,989.94	7,524,509.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,520,516.00	30,287,133.75
210408	Бараа материал акталсны зардал	243,262,769.93	-
2105	Норматив зардал	18,306,076,609.44	17,926,909,917.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,306,076,609.44	17,926,909,917.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	354,667,078.00	257,595,886.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	336,444,258.00	233,240,776.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,000,000.00	17,816,310.00
210604	Урсгал засвар	9,222,820.00	6,538,800.00
2107	Томилолт, зочны зардал	89,359,133.00	120,656,798.00
210702	Дотоод албан томилолт	89,359,133.00	120,656,798.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,241,717,486.46	6,555,089,662.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,240,475,805.96	6,547,578,798.63
210803	Даатгалын үйлчилгээ	427,680.00	481,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.50	930,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	6,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,595,346.95	103,410,237.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,594,520.00	3,533,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,000,826.95	99,877,237.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	474,284,635.21	107,716,516.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,087,368.00	20,259,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	13,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,361,368.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,726,000.00	7,259,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	431,197,267.21	87,457,016.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	275,594,067.21	87,457,016.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	155,603,200.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,634,478,505.66)	1,941,248,432.42
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,715,595,609.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	136,362,474.00	-
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	2,579,233,135.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(6,350,074,114.66)	1,941,248,432.42

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	870,951,254.96	182,864.39	5,983,682,674.49	6,854,816,793.84
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,951,254.96	182,864.39	5,983,682,674.49	6,854,816,793.84
9	Тайлант үеийн үр дүн			(6,350,074,114.66)	(6,350,074,114.66)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	870,951,254.96	182,864.39	(366,391,440.17)	504,742,679.18
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			79,585,000.00	79,585,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	870,951,254.96	182,864.39	(286,806,440.17)	584,327,679.18
19	Тайлант үеийн үр дүн			1,941,248,432.42	1,941,248,432.42
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	870,951,254.96	182,864.39	1,654,441,992.25	2,525,576,111.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	31,456,661,306.93	27,295,747,758.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,674,500.00	35,382,236.00
120	Нийтлэг татварын бус орлого	164,674,500.00	35,382,236.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,674,500.00	35,382,236.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,878,050.00	35,382,236.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,796,450.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,291,986,806.93	27,260,365,522.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,848,261,630.00	23,679,617,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,848,261,630.00	23,679,617,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,443,725,176.93	3,580,747,622.89
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,443,725,176.93	680,747,622.89
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,900,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,545,473,951.93	27,176,152,068.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,545,473,951.93	27,176,152,068.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,563,490,493.83	27,041,298,462.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	572,288,249.49	625,237,245.89
210101	Үндсэн цалин	383,837,211.04	435,760,857.12
210102	Нэмэгдэл	145,003,238.45	145,519,012.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,447,800.00	43,957,376.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,036,872.26	81,699,313.02
210201	Тэтгэврийн даатгал	60,718,372.26	56,468,695.07
210202	Тэтгэмжийн даатгал	5,079,600.00	6,705,399.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,063,700.00	4,940,058.25
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015,900.00	1,235,014.64
210205	Эрүүл мэндийн даатгал	10,159,300.00	12,350,145.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,038,667.00	14,598,970.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,088,200.00
210302	Түлш, халаалт	-	1,696,470.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,667,300.00
210304	Байрны түрээс	9,038,667.00	7,147,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	35,333,629.94	36,759,089.75
210401	Бичиг хэрэг	9,199,150.00	9,936,380.00
210402	Тээвэр, шатахуун	9,928,200.00	8,438,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,335,989.94	7,524,509.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,870,290.00	10,860,000.00
2105	Норматив зардал	11,755,353,289.34	17,710,559,320.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,755,353,289.34	17,710,559,320.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	436,592,148.00	264,852,947.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	417,581,328.00	243,321,597.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,000,000.00	14,950,750.00

210604	Урсгал засвар	10,010,820.00	6,580,600.00
2107	Томилолт, зочны зардал	89,359,133.00	119,728,900.00
210702	Дотоод албан томилолт	89,359,133.00	119,728,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,577,743,104.80	8,183,986,676.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,576,501,424.30	8,165,675,812.42
210803	Даатгалын үйлчилгээ	427,680.00	481,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.50	930,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	16,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,745,400.00	3,876,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,745,400.00	3,876,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	981,983,458.10	134,853,606.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,087,368.00	20,259,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,361,368.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,726,000.00	7,259,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	938,896,090.10	114,594,106.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	411,390,517.21	87,457,016.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	527,505,572.89	27,137,089.89
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,911,187,355.00	119,595,690.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,911,187,355.00	119,595,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,911,187,355.00	119,595,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,911,187,355.00	119,595,600.00
222001	Тоног төхөөрөмж	2,844,396,800.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,790,555.00	119,595,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,911,187,355.00)	(119,595,600.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	90.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	90.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,679,618,000.00	23,627,543,119.17	52,074,880.83	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,679,618,000.00	23,627,543,119.17	52,074,880.83	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,659,276,700.00	23,607,283,619.17	51,993,080.83	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,261,300.00	625,237,245.89	38,024,054.11	94.3
210101	Үндсэн цалин	441,089,600.00	435,760,857.12	5,328,742.88	98.8
210102	Нэмэгдэл	162,728,900.00	145,519,012.52	17,209,887.48	89.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,442,800.00	43,957,376.25	(4,514,576.25)	111.5
210104	Урамшуулал	20,000,000.00		20,000,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,468,200.00	81,699,313.02	8,768,886.98	90.3
210201	Тэтгэврийн даатгал	63,662,800.00	56,468,695.07	7,194,104.93	88.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,701,300.00	6,705,399.47	(4,099.47)	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,361,100.00	4,940,058.25	421,041.75	92.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,340,300.00	1,235,014.64	105,285.36	92.1
210205	Эрүүл мэндийн даатгал	13,402,700.00	12,350,145.59	1,052,554.41	92.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,652,000.00	14,598,970.00	53,030.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	4,088,200.00	4,088,200.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	1,696,500.00	1,696,470.00	30.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,667,300.00	1,667,300.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	7,200,000.00	7,147,000.00	53,000.00	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	29,936,700.00	29,761,889.75	174,810.25	99.4
210401	Бичиг хэрэг	6,109,700.00	5,936,380.00	173,320.00	97.2
210402	Тээвэр, шатахуун	8,439,000.00	8,438,200.00	800.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,525,200.00	7,524,509.75	690.25	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,862,800.00	7,862,800.00	0.00	100.0
2105	Норматив зардал	14,811,801,000.00	14,810,559,320.09	1,241,679.91	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,811,801,000.00	14,810,559,320.09	1,241,679.91	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	186,446,700.00	185,883,271.00	563,429.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	164,490,000.00	164,351,921.00	138,079.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,256,700.00	14,950,750.00	305,950.00	98.0
210604	Урсгал засвар	6,700,000.00	6,580,600.00	119,400.00	98.2
2107	Томилолт, зочны зардал	95,546,600.00	94,929,700.00	616,900.00	99.4
210702	Дотоод албан томилолт	95,546,600.00	94,929,700.00	616,900.00	99.
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,763,288,200.00	7,760,737,909.42	2,550,290.58	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,743,688,900.00	7,742,427,045.42	1,261,854.58	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	562,000.00	481,140.00	80,860.00	85.6

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	938,300.00	930,724.00	7,576.00	99.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,000,000.00	16,800,000.00	1,200,000.00	93.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,876,000.00	3,876,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,876,000.00	3,876,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,341,300.00	20,259,500.00	81,800.00	99.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,341,300.00	20,259,500.00	81,800.00	99.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,341,300.00	7,259,500.00	81,800.00	98.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,679,618,000.00	23,627,543,119.17	52,074,880.83	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,679,618,000.00	23,592,160,883.17	87,457,116.83	99.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	23,679,618,000.00	23,592,160,883.17	87,457,116.83	99.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	35,382,236.00	(35,382,236.00)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	35,382,236.00	(35,382,236.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	89	89	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	44	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	42	42	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44	44	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	39	39	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,580,747,532.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,580,747,532.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,553,610,443.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,997,200.00
210401	Бичиг хэрэг		4,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,997,200.00
2105	Норматив зардал		2,900,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		2,900,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		91,015,276.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		91,015,276.00
2107	Томилолт, зочны зардал		24,799,200.00
210702	Дотоод албан томилолт		24,799,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		530,798,767.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		530,798,767.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		27,137,089.89
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		27,137,089.89
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		27,137,089.89
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,580,747,622.89
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		680,747,622.89
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,900,000,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		90.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад, бараа материалын эргэц, чанарт тавих дотоод хяналт, худалдан авах ажиллагаанд мөрдөгддөг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ний хооронд аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Л.Мөнхцацрал, аудитор Ц.Мөнхтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/250 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мал эмнэлгийн ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ: Үүнд:

- Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг тархвар зүйн судалгаанд үндэслэн төлөвлөж, улсын хэмжээнд зохион байгуулах;
- Мал, амьтны шинэ болон дахин сэргэж буй өвчнүүд, зарим нутаг дэвсгэрт эндемик хэлбэрээр гарч байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан өвчлөлийн шалтгаан, нөхцөлийг судалж, тэмцэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;
- Гоц халдварт, зооноз өвчний гаралт, тархалтын байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, зарим өвчнөөр эрүүл, тайван байдлыг аймаг, бүс, нутгаар баталгаажуулж, нийтэд зарлан мэдээлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажуулалтын тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлж, мал эмнэлгийн мэргэжлийн баталгаа бүхий хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр хүн амыг хангах;
- Мал эмнэлгийн сүлжээ итгэмжлэгдсэн лабораторийн тогтолцоог бүрдүүлж, бүсчлэн хөгжүүлж, чадавхыг дээшлүүлж үндэсний болон бүс нутгийн лавлагаа лабораторийн түвшинд хүргэх;

- Мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор эрсдэлд суурилсан мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- Мал эмнэлгийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж, мэргэжлийн ёс зүйн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх.

Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн А/385 дугаар тушаалаар баталсан салбарын төсөвт байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Засгийн газрын 2018 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 186 дугаар тогтоолоор мал эмнэлгийн байгууллагыг бүтэц тогтолцоо, орон тооны хязгаарыг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А-46 тушаалаар “Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрөөр тус газрын орон тооны дээд хязгаарыг 44 байхаар баталсныг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төсвийн шууд захирагчийн байгууллагад явцын болон гүйцэтгэлийн дотоод хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж Шилэн дансны тайлангийн тоон мэдээллийг холбогдох маягтад үнэн зөв бөглөөгүй, тайлагнаж ирүүлсэн мэдээлэл нь shilendans.gov.mn сайтын мэдээллээс зөрүүтэй дутагдлууд байгааг ажил хариуцсан мэргэжилтэнтэй тухай бүр холбогдож, мэдээллийг залруулж, үнэн зөв тайлагнах талаар мэргэжил арга зүйгээр хангасан;
- Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт, тавьж биелэлтийг нэгтгэн Үндэсний аудитад хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 23,679,618.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 355,194.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мал, эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 370,115.2 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.09	0.09
Авлага	507,777.3	1,011,894.4	504,117.2
Урьдчилгаа	-	20,750.0	20,750.0
Бараа материал	1,083,947.9	688,918.8	(395,029.1)
Үндсэн хөрөнгө	563,737.7	804,014.7	240,277.1
Нийт хөрөнгө	2,155,462.9	2,525,578.1	370,115.2
Өр төлбөр	1,650,720.2	2.0	(1,650,718.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	504,742.7	2,525,576.1	2,020,833.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,155,462.9	2,525,578.1	370,115.2

Авлага дансны үлдэгдэл 1,011,894.4 мянган төгрөг болж 504,117.2 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 480,561.7 мянган төгрөгөөр буурсан, шүлхийн вакцин яаралтай горимоор худалдан авахаар ОХУ-ын Бүх холбоотын малын эрүүл мэндийн газартай хийсэн гэрээний урьдчилгаа төлбөрт 984,756.9 мянган төгрөгийг оны эцэст шилжүүлж, ажилчидтай холбоотой авлагын дансанд цалингийн тооцооны зөрүүний 78.0 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 20,750.0 мянган төгрөг болж өссөн нь 2021 оны төсвөөс “Open gov” мал эмнэлгийн нэгдсэн системийн дараа жилийн үйлчилгээний хөлс 20,750.0 мянган төгрөгийг урьдчилж төлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 688,918.8 мянган төгрөг болж 395,029.1 мянган төгрөгөөр буурсан нь мал, эмнэлгийн үйл ажиллагаанд зориулж 11,923,300.3 мянган төгрөгийн вакцин, эм, эмийн бодис худалдан авсан, 778,576.1 мянган төгрөгийн эмийн бодисыг хандив тусламжаар хүлээн авч, орон нутгийн мал эмнэлгийн салбаруудаар дамжуулан 13,108,668.0 мянган төгрөгийн вакцин, эмийн бодисыг шүлхий, мялзан зэрэг малын гоц халдварт өвчинтэй тэмцэхэд зарцуулж, бичиг хэрэг болон бусад хангамжийн материал 11,762.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 804,017.7 мянган төгрөг болж 240,277.1 мянган төгрөгөөр өссөн нь урсгал зардлаас 119,595.0 мянга, “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн санхүүжилтээс 67,837.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус бэлтгэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны А-1/819 дугаар албан бичгээр 82,800.0 мянган төгрөгийн автомашиныг балансаас балансад шилжүүлэн авч, өмнөх оны тайланд зардлаар бүртгэсэн 79,585.0 төгрөгийн программ хангамжийг биет бус хөрөнгөд залруулан бүртгэж, тайлант онд 109,537.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2.0 мянган төгрөг болж 1,650,718.2 төгрөгөөр буурсан нь оны эхэнд бүртгэлтэй байсан орон нутгийн мал эмнэлгийн салбаруудад төлөх вакцин тарилтын үйлчилгээний төлбөрийн 1,563,985.8 мянган төгрөгийн өглөг, программ хангамж хөгжүүлэлтийн ажлын төлбөрт төлөх 79,585.0 төгрөгийн өглөг, бусад 7,149.4 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,525,576.1 төгрөг болж 2,020,833.4 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үр дүнг залруулах бичилтээр 79,585.0 мянган төгрөгөөр, тайлант оны үйл ажиллагааны үр дүн 1,941,248.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мал, эмнэлгийн ерөнхий газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 1,089,691.9 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан нь Олон улсын байгууллагын хандив, тусламжийн орлого 719,241.7 мянган төгрөгөөр, улсын төсвийн санхүүжилт 3,168,643.7 мянган төгрөгөөр, татварын бус орлого 101,806.4 мянган төгрөгөөр буурч, Засгийн газрын нөөц хөрөнгөөс малын гоц халдварт шүлхий өвчний тархалтыг бууруулахад шаардлагатай вакцины төлбөрт 2,900,000.0 мянган төгрөгийг нэмж хуваарилсантай холбоотой байна.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 5,686,627.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 379,166.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 243,629.4 мянган төгрөгөөр бууруулсан нь өмнөх оноос үйл ажиллагааны үр дүн 8,291,322.5 мянган төгрөгөөр өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мал, эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны урсгал үйл ажиллагааны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөг 59,829,896.2 мянган төгрөгөөр боловсруулж, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг хянахдаа 26,690,674.9 мянган төгрөгөөр бууруулж, Улсын Их Хурлаар 2021 оны Төсвийн тухай хуулиар 33,139,221.3 мянган төгрөг байхаар баталжээ.

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар төсвийн зардлын хэмнэлттэй уялдуулан урсгал зардлыг 23,679,618.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Салбарын төсвийг өмнөх оны суурь төсвөөр хянаж, бууруулснаар малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт бүрэн хангагдахгүйд хүрч, худалдан авахаар төлөвлөсөн зарим өвчний вакцины төсвийг шүлхий өвчний вакцинжуулалт, тарилгын үйлчилгээнд зарцуулахад хүргэсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 23,679,617.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 35,382.2 мянган төгрөг бүрдүүлж, нийт 23,715,000.1 мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлснээс бараа, үйлчилгээний зардалд 23,607,283.6 мянган төгрөг, тэтгэмж, урамшууллын зардалд 20,259.5 мянган төгрөг зарцуулж, 87,457.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, төсвийн зардлын нийт гүйцэтгэл 23,627,543.1 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Тайлант онд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү 52,074.9 мянган төгрөг, төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсөв 46,792.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдаж, бусад төсөв 5,281.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	Үндсэн үйл ажиллагаа					
1.1	80801	Үндсэн үйл ажиллагааны зардал	884,449.4	834,998.4	(49,451.0)	94.4
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	20,341.3	20,259.5	(81.8)	99.6
1.3	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	41,457.2	41,457.2	(0.03)	100.0
2	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ					
2.1	82504	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	649,781.5	649,781.5	0	100.0
2.2	82506	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	15,191,930.5	15,190,389.1	(1,541.4)	100.0
2.3	82507	Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх	2,894,229.3	2,894,190.8	(38.5)	100.0
2.4	82508	Малын өвчний лабораторийн оношилгоо, шинжилгээ	905,215.3	905,215.2	(0.1)	100.0
2.5	82510	Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлт	689,689.9	689,689.8	(0.1)	100.0
2.6	82548	Мал амьтан эрүүлжүүлэх	2,402,523.6	2,401,561.6	(962.0)	100.0
		Дүн	23,679,618.0	23,627,543.1	(52,074.9)	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 2,900,000.0 мянган төгрөг, өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа гадаадын төсөл хөтөлбөрөөс 680,747.6 мянган төгрөг нийт 3,580,747.6 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлжээ.

Засгийн газрын 2021 оны “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 303 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас малын гоц халдварт шүлхий өвчний 16 аймгийн 79 суманд гарсан шаардлагатай вакцин худалдан авахад 2,900,000.0 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсныг, хүлээн авч зарцуулсан байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Ногоон алт- малын эрүүл мэнд” төслийн санхүүжилтээр 680,747.6 мянган төгрөгийн орлого төвлөрснийг батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу 653,610.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 27,137.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2018 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 186 дугаар тогтоолоор мал эмнэлгийн байгууллагын бүтэц тогтолцоо, орон тооны хязгаарыг баталж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны “Мал эмнэлгийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” А-46 тушаалаар Төсвийн шууд захирагчийн орон тоог 44 байхаар тогтоосныг хэрэгжүүлж ажилласан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь 2021 оныг мал эмнэлгийн бүх шатны мэргэжилтнүүдийг чадавхжуулан, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг зохион байгуулах ажлыг тэргүүний зорилго болгож, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 32 зорилт бүхий 73 арга хэмжээг төлөвлөснөөс 58 арга хэмжээ 100 хувь, 5 арга хэмжээ 90 хувь, 9 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, нийт биелэлт 94.9 хувь байна.

Мал, амьтны гоц халдварт өвчний нөхцөл байдал болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

2021 оны хавраас эхлэн улсын хэмжээнд шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах зэрэг олон улсын худалдааны хөл хориот, вирусээр үүсгэгддэг мал, амьтны гоц халдварт өвчнүүд бүртгэгдэж, уг өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг холбогдох заавар, журмын дагуу хэрэгжүүлэн ажилласнаас бог малын мялзан, хонины цэцэг өвчнүүдийг бүрэн хяналтад авсан байна.

Харин гоц халдварт шүлхий өвчний гаралт нэмэгдэж, оны эцсийн байдлаар 20 аймгийн 144 суманд шүлхий өвчний 267 голомт бүртгэгдэн, нийт 96,392 толгой мал, амьтан өвчилсөн байна. Улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн тохиолдлын 76.0 хувь (74.047 толгой) бог мал, 23.0 хувь (22.305 толгой) үхэр, 1.0 хувь (40 толгой)-ийг зээр эзэлж байна.

2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 16 аймгийн 79 сум, 144 голомтод хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлж, 6 аймгийн 8 сум, 18 голомт хязгаарлалтын дэглэмд шилжээд байна. Мөн 11 аймгийн 57 сум, 105 голомтын хорио цээрийн дэглэмийг цуцалсан байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг нийт 3 удаагийн татан авалтаар 10.0 сая тун хүлээн авч, нийт 14 аймгийн 124 сумын нийт 16.2 сая толгой малыг дархлаажуулахад 12,156,358.9 мянган төгрөгийн вакцин, дархлаажуулалтын үйлчилгээний хөлсөнд нийт 3,544,700.0 мянган төгрөг зарцуулсан боловч халдварт өвчний голомтыг хумих, тархалтыг зогсоох ажил төдийлөн үр дүнд хүрээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил нь худалдан авах ажиллагааг шударга, хариуцлагатай зохион байгуулах, түүнд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, эм, эмнэлгийн бэлдмэлийн хяналт, эргэцийн удирдлагыг сайжруулах асуудлуудыг хөндөж байна.

Үүн дотроос гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 1,200,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн боловч хэрэгжилтийг хангаагүй, төсвийг шүлхий өвчний тарилгын үйлчилгээ, вакцин худалдан авалтад шилжүүлэн зарцуулснаас төлөвлөгөөт дархлаажуулалтын гүйцэтгэл бүрэн хангагдаагүй, эмийн бодисын заавал байлгах нөөц дууссан байна. Энэхүү асуудал нь худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас хууль хяналтын байгууллагаар вакцины худалдан авалттай холбоотой асуудал шалгагдаж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 142 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дараах мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу мэдээлээгүй байна. Үүнд:

- Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайланг шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулаагүй;
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх 10 төрлийн 537,624.2 мянган төгрөгийн тушаал, шийдвэрийг байршуулаагүй;
- Батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төслийг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилын хүрээнд дараах асуудлууд байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хянахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хавар, намрын дархлаажуулалтад шаардагдах 8,206,147.1 мянган төгрөгийн 10 сая тун шүлхийн вакциныг шууд худалдан авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн боловч Төсвийн асуудал эрхэлсэн, төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдээгүй, гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины 1,200,000.0 мянган төгрөгийн, ариутгал халдваргүйжүүлэлтийн хувцас, бодисын 80,000.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хэрэгжүүлээгүйгээс төлөвлөгөөт дархлаажуулалтын зарим ажлын гүйцэтгэл хангагдаагүй, эмийн бодисын заавал байлгах нөөцийг бүрдүүлж ажиллагаагүй байна. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас хууль хяналтын байгууллагаар вакцины худалдан авалттай холбоотой асуудалд зарим албан хаагчийг холбогдуулан шалгаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “мал эмнэлгийн үйлчилгээг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан тэгш, хүртээмжтэй хүргэх”, 6 дугаар зүйлийн 6.6 “Малын халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй, эсхүл мал эмнэлгийн үйлчилгээний заавар, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас бусдад учирсан хохирлыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хариуцна”, 9 дүгээр зүйлийн 9.9 “Дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна”, 13 дугаар зүйлийн 13.6 “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үед дайчлах зориулалт бүхий нөөцтэй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,315,000.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 900.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилтийг хянахад бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	900.0	1	900.0	-	-	-
Зөвлөмж	4	1,314,100.0	4	1,314,100.0	-	-	-
Нийт дүн	5	1,315,000.0	5	1,315,000.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дархлаажуулалтын төлөвлөлт, хэрэгжилт, вакцины худалдан авалттай холбоотой хууль, хяналтаар шалгагдаж буй асуудлын шийдвэрлэлт, дотоод хяналтын тогтолцооны талаар горим, сорил хэрэгжүүлж, энэ талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хянаж, үнэлэх нь ач холбогдолтой байна.

Мөн улсын хэмжээнд голомтлон тархсан шүлхий өвчинтэй тэмцэхэд авч хэрэгжүүлсэн арга, хэмжээ, түүнд зарцуулсан төсөв хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 367,942.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 79,585.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 178,731.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 109,626.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 288,357.3 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 355,194.3 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Өмнөх онд зардлаар бүртгэсэн 79,585.0 мянган төгрөгийн мэдээлэл технологийн биет бус хөрөнгийг тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэснийг, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөд тусган өмнөх үеийн үр дүнрүү хаалтын бичилт хийж залруулсан.

4.3 Албан шаардлага

1. Мал эмнэлгийн эмийн нөхөн сэлгэлтийг зохистой гүйцэтгээгүй, вакцины чанар, эргэцэд тавих дотоод хяналт сул байгаагаас 113,358.8 сая төгрөгийн вакцины хугацаа дууссан, байгууллагын удирдлага солигдсоноос 1,012.0 мянган төгрөгийн 1680 ширхэг үнэт цаас хүчингүй болсон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1 “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Мал эмнэлгийн улсын байцаагч мал, амьтны эмийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд хяналт тавьж, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 24.4.1.мал, амьтны эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, сорилт, баталгаажуулалт хийгдээгүй эмийг эгүүлэн татах, эсхүл устгах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

2. Бараа материалын дансанд 21,206.2 мянган төгрөгийн 9 нэр төрлийн үндсэн хөрөнгө, эргэлт удааширсан 43,154.1 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.49 "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг; 16.5 Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/73 дугаар тушаалаар баталсан Тандалтын төлөвлөгөө, зардлын төсөвт тусгагдаагүй 2 арга хэмжээнд 41,400.0 мянган төгрөг зарцуулсан нь Мал эмнэлгийн эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Улсын хэмжээнд халдварт өвчнийг тандах төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сард багтаан энэ хуулийн 28.9-д заасан мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, хэрэгжилтийг зохион байгуулна", 14.6 "Энэ хуулийн 14.1-д заасан төлөвлөгөө, 14.5-д заасан шинжилгээний дүнг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн халдварт өвчингүй, тайван улс, бүс, нутгийн талаар нийтэд мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Тандалтын аливаа ажлыг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн дагуу зарцуулах, төлөвлөгөө, төсөвт батлагдаагүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Анхны өртгөө нөхсөн 87,300.0 мянган төгрөгийн автомашин, 50,838.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн ашиглах жил, үнийг дахин тооцож, данс бүртгэлд тусгаагүй байна. Мөн 97,740.0 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн тавилга эд хогшил үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.2 "...ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗГ-тай зөвшилцөн тогтоож, данс бүртгэлд тусган, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, үлдэх өртөггүй хөрөнгийг чанар, байдлаар ангилж, холбогдох арга хэмжээг авах.

3. Авлагын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс дараа оны мэдээлэл технологийн үйлчилгээний төлбөрт 20,750.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс дараа жилийн төсөвт хамаарах ажил, үйлчилгээний төлбөрт урьдчилан шилжүүлэхгүй байх, төсвийг үр ашигтай удирдах.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан элэгдэл тооцоход баримтлах хугацааг бууруулж, компьютер, тоног төхөөрөмжийн ашиглалтын жилийг 3 жилээр тооцсоноос 56 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 11,190.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй, толилуулга, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох мөрдөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх.

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Эдийн засгийн ангилал зөрчиж бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын төсвөөс 7,200.0 мянган төгрөгийн шатахуун, 6,622.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, толилуулга, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Эдийн засгийн ангилал зөрчиж, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал зарцуулахгүй байх, цаашид төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

6. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Сүүлийн гурван жилийн төсвийн гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 17,000.0 мянгаас 25,000.0 мянган төгрөгийн орлогыг тогтмол төвлөрүүлдэг нь орлогыг төлөвлөж, хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

6.2. Өгсөн зөвлөмж:

Бодит гүйцэтгэлд үндэслэн өөрийн орлогыг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тусган төлөвлөж, хэрэгжүүлэх.

7. Зардлын данстай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын төсвөөс 1,804.5 мянга, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын төсвөөс 5,140.0 мянга, нийт 6,944.5 мянган төгрөгийн зардлыг ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт хамруулахад зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" , Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.2. Өгсөн зөвлөмж:

Улсын төсвөөс албан хаагчдын төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлыг хариуцан төлж байгаа тул, Засгийн газрын 2021 оны 43 дугаарт тогтоолын хэрэгжилтийг хангуулж, эрүүл мэндийн үзлэгт нэмж зардал зарцуулахгүй байх, төсвийг хэмнэлттэй зарцуулах

8. Болзошгүй өр төлбөрийн талаар

8.1. Илрүүлэлт:

Тайлант онд шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд 5,518.3 мянган төгрөгийн нөхөн олговрыг олгох тухай шийдвэр гарсан боловч хэрэгжилт хангагдаагүй, буруутай албан тушаалтнаар төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүйгээс нь шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлтэй холбоотой өр төлбөр үүсэж болзошгүй байна.

8.2. Өгсөн зөвлөмж:

Болзошгүй өр төлбөрийн асуудлыг нягталж, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргасан буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар												
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Шүүхийн шийдвэртэй холбоотой 5,518.3 мянган төгрөгийн болзошгүй өр төлбөр байна.	Шүүхийн шийдвэртэй үүсэж болзошгүй өр төлбөрийн асуудлыг судалж, хуульд нийцүүлж шийдвэрлэх	1	5,518.3					1	5,518.3
2	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын төсвөөс 6,944.5 мянган төгрөгийн зардлыг ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт хамруулахад зарцуулсан байна.	Төсвийг хэмнэлттэй зарцуулах	1	6,944.5					1	6,944.5
3	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 11,190.5 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	Элэгдэл тооцох хугацааг НБББББ-т нийцүүлж тогтоох, төсвийн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	1	11,190.5					1	11,190.5
4	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Анхны өртгөө нөхсөн 87,300.0 мянган төгрөгийн автомашин, 50,838.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн ашиглах жил, үнийг дахин тооцож, данс бүртгэлд тусгаагүй байна.	Хөрөнгийг дахин үнэлж, төсвийн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	1						1	-
5	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Бараа материалын дансанд 21,206.2 мянган төгрөгийн 9 нэр төрлийн үндсэн хөрөнгө, эргэлт удааширсан 43,154.1 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.	Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах	1	64,360.3			1.0	64,360.3		
6	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Вакцины чанар, хадгалалт, эргэцэд тавих дотоод хяналт сул байгаагаас 113,358.8 сая төгрөгийн вакцины хугацаа дууссан, байгууллагын удирдлага солигдсоноос 1,012.0 мянган төгрөгийн 1680 ширхэг үнэт цаас хүчингүй болсон байна.	Вакцины эргэц, ашиглалтын дотоод хяналтыг сайжруулах, үр ашиггүй зардал гаргахгүй байх	1	114,370.8			1	114,370.8		

**Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

7	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 7,200.0 мянган төгрөгийн шатахуун, 6,622.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал зарцуулсан.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах	1	13,822.9					1	13,822.9
8	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Тандалтын төлөвлөгөө, зардлын төсөвт тусгагдаагүй 2 арга хэмжээнд 41,400.0 мянган төгрөг зарцуулсан.	Тандалтын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх	1	41,400.0					1	41,400.0
9	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 20,750.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн.	Төсвийг зохистой удирдах	1	20,750.0					1	20,750.0
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Сүүлийн гурван жилийн төсвийн гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 17,000.0 мянгаас 25,000.0 мянган төгрөгийн орлогыг тогтмол төвлөрүүлсэн нь орлогыг төлөвлөж, хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.	Өөрийн орлогыг төсөвт төлөвлөж байх	1	10,000.0					1	10,000.0
11	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Өмнөх онд Малын эмийн бүртгэл нэгдсэн мэдээллийн сан Мэдээлэл технологийн биет бус хөрөнгийг зардлын дансанд бүртгэснийг тайлант онд залруулахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн	НББ-ын бичилтийг залруулах	1	79,585.0	1	79,585.0				
	ДҮН			-	11	367,942.3	1	79,585.0	2	178,731.1	8	109,626.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал												
1	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Хавар, намрын дархлаажуулалтад шаардагдах 8,206,147.1 мянган төгрөгийн 10 сая тун шүлхийн вакциныг шууд худалдан авсан боловч Төсвийн асуудал эрхэлсэн, төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдээгүй, 1,280,000.0 мянган төгрөгийн вакцин, эмийн бодисыг худалдан авахаар төлөвлөж, гэрээ байгуулсан боловч хэрэгжилтийг хангуулаагүй.	Худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, товлосон дархлаажуулалтыг гүйцэтгэх, ХАА-д тавих дотоод хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх	1	1,280,000.0			1	1,280,000.0		
2	Мал эмнэлгийн ерөнхий газар	АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож, тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх 10	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах			1	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах		

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

		төрлийн 537,624.2 мянган төгрөгийн тушаал, шийдвэр, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг тус тус мэдээлээгүй байна.									
ДҮН			-	2	1,280,000.0	-	-	2	1,280,000.0	-	-
НИЙТ ДҮН				13	1,647,942.3	1	79,585.0	4	1,458,731.1	8	109,626.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 80/АД160043

Улаанбаатар хот

АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд 21,206,200.00 төгрөгийн 9 нэр төрлийн үндсэн хөрөнгө, мөн эргэлт удааширсан 43,154,100.00 төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4 "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулах, холбогдох асуудлыг эрх бүхий байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-74.Docx

001080249



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 81/АД160093

Улаанбаатар хот

АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хавар, намрын дархлаажуулалтад шаардагдах 8,206,147,200.00 төгрөгийн 10 сая тун шүлхийн вакциныг шууд худалдан авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн боловч Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдээгүй, гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 1,200,000,000.00 төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн боловч хэрэгжилтийг хангаагүй, ариутгал халдваргүйжилтийн хувцас, бодис 80,000,000.00 төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулсныг хэрэгжүүлээгүй зэргээс төлөвлөгөөт дархлаажуулалтын зарим ажлын гүйцэтгэл хангагдаагүй, эмийн бодисын заавал байлгах нөөцийг бүрдүүлж ажиллагаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 34 дүгээр зүйлийн 34.3 "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "мал эмнэлгийн үйлчилгээг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан тэгш, хүртээмжтэй хүргэх", 6 дугаар зүйлийн 6.6 "Малын халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй, эсхүл мал эмнэлгийн үйлчилгээний заавар, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас бусдад учирсан хохирлыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хариуцна", 9 дүгээр зүйлийн 9.9 "Дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна", 13 дугаар зүйлийн 13.6 "Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үед дайчлах зориулалт бүхий нөөцтэй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө",

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-71.Docx

001080234

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу шударга, хариуцлагатай зохион байгуулж байх;
2. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, энэ талаар байгууллагын дотоод дүрэм, журамд хариуцлага, хяналтын заалтуудыг нэмж тусган, гүйцэтгэлийг хангуулах;
3. Дархлаажуулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, хэрэгжилтийг бүрэн хангуулах, мал эмнэлгийн эмийн заавал байлгах нөөцийг бүрдүүлж, эргэцэд хяналт тавьж, сэлгэлт хийн шинэчилж байх;
4. Зөрчлийг арилгаж албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
5. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Л.МӨНХЦАЦРАЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-71.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 82/АД160043

Улаанбаатар хот

АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож, тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан, төсөв, өмч хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх 10 төрлийн 537,624,201.41 төгрөгийн тушаал, шийдвэр, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
900 110.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-72.Docx

001080236



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 79/АД/60073
АХГ-2022/344/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал эмнэлгийн эмийн нөхөн сэлгэлтийг зохистой гүйцэтгээгүй, вакцины чанар, эргэцэд тавих дотоод хяналт сул байгаагаас 113,358,800.00 төгрөгийн вакцины хугацаа дууссан, мал байгууллагын удирдлага солигдсоноос 1,012,000.00 төгрөгийн 1680 ширхэг үнэт цаас хүчингүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн "Мал эмнэлгийн улсын байцаагч мал, амьтны эмийн үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд хяналт тавьж, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 24.4.1.мал, амьтны эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, сорилт, баталгаажуулалт хийгдээгүй эмийг эгүүлэн татах, эсхүл устгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Вакцины чанар, эргэцэд тавих дотоод хяналтыг сайжруулах, үр ашиггүй зардал гаргахгүй байх;
2. Үнэт цаасны эх бэлтгэлийг үргэлжлүүлэн ашиглах боломжтойгоор хэвлүүлэх, ашиглалтыг сайжруулах;
3. Дээрх зөрчлийг арилгаж албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

0006109
0010.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-75.Docx

001000051